



УЛААНБААТАР  
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1987 оны 10 сарын 5 өдөр

Дугаар 292

Улаанбаатар хот

Угаалга, хими цэвэрлэгээний шинэ комбинат ашиглалтанд орохтой холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Угаалга, хими цэвэрлэгээний комбинатыг ашиглалтанд авсантай холбогдуулан зарим бэлтгэл ажил хангах, ажилчдын ахуй хангамжийг сайжруулах, үйлчилгээний цэг салбарыг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

Нэг. Улаанбаатар хотын Ажилчны районы нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтанд орж буй Угаалга, хими цэвэрлэгээний комбинатыг "Туул" гэж нэрлэсүгэй.

Хөёр. "Туул" комбинатын гадна талын гэрлэн чимэглэлийг энэ оны 10 дугаар сард багтаан чанартай хийж гүйцэтгэхийг Гэрэлтүүлэг чимэглэлийн үйлдвэр /н.Хомоол/-т даалгасугай.

Гурав. "Туул" комбинатын гадна талын гэрлэн чимэглэлийг хийхэд шаардагдах хөрөнгийг Хот тохижуулах зардлаас гаргахыг Хот тохижуулах газар /н.Баатар/-т зөвшөөрсүгэй.

Дөрөв. Ахуйн үйлчилгээний удирдах газар /н.Надмид/-т даалгах нь:

1. Угаалга, хими цэвэрлэгээний комбинат ашиглалтанд орохтой холбогдуулан 1987 оны IY улирал, 1988 оны эхний хагас жилд багтаан хими цэвэрлэгээний хүлээн авах, олгох цэгийг хавсралт № 1-д заасны дагуу 13-аар нэмэгдүүлж, 40-д хүргэсүгэй.

2. Нийтийн аж ахуй, үйлчилгээний яам, Эрүүлийг хамгаалах яамны саналыг үндэслэн төрөх газруудын угаалгын II цехийн ажлыг шинэ комбинатад шилжүүлэн ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан тусгай шугам гарган үйлчилж байхаар зохион байгуулсугай.

3. Хими цэвэрлэгээ, угаалгын комбинатын хуучин байранд Үсчин, гэрэл зургийн захиргаа, бүртгэлийн машинт станцыг шилжүүлэн, амины авто машины үйлчилгээ, тохируулгын цех, Үсчин гэрэл зургийн захиргааны хуучин байранд Чамин хийцийн гутал захиалгаар үйлдвэрлэх тасгуудыг 1987 оны IY улиралд багтаан тус тус нээж ажиллуулсугай.

4. Үйлдвэр, албан байгууллагын дэргэд ажиллах хүлээн авах, олгох цэгийг хавсралт № 2-д заагдсан 10 газарт нээж, үйлчилгээг гэрээний дагуу графикт хугацаанд нь хийж байсугай.



Тав.Нийтийн хоолны удирдах газар /н.Урианхай/-т даалгах нь:

1."Туул" комбинатын дэргэд 60 хүний суудалтай цайны газрыг 1987 оны IY улиралд багтаан нээж ажиллуулсугай.

2.Тус цайны газраар "Туул" комбинат, Автобусны I паркийн ажилчин албан хаагчдыг хамруулан үйлчилж байсугай.

Зургаа.Комбинатын дэргэд цехийн эмнэлэг байгуулж ажиллуулахыг Үйлдвэрийн эмнэлэг, мэргэжлийн өвчний улсын диспансер /н.Мөнхчулуун/-т даалгасугай.

Долоо.Цайны газарт хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг Нийтийн хоолны удирдах газрын 1987 оны IY улирлын хуваарьт нэмж оруулахыг Хотын төлөвлөгөөний комисс /н.Ганбаатар/-т зөвшөөрсүгэй.

Найм.Автобусны I паркаас "Туул" комбинат хүртлэх замын зургийг 1988 онд хийлгэж 1989 онд гүйцэтгүүлэхийг хотын төлөвлөгөөний комисс /н.Ганбаатар/, Их барилгын хэлтэс /н.Нэргүй/, Орон сууц,нийтийн үйлчилгээний хэлтэс /н.Зул/-т даалгасугай.

Ес.Энэ тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Орон сууц, нийтийн үйлчилгээний хэлтэс /н.Зул/-т үүрэг болгосугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

*[Handwritten signature]*  
С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАРИУЦ-  
ЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

*[Handwritten signature]*  
Д.АЛГИА

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэт-  
гэх захиргааны 1987 оны  
тоот тогтоолын хавсралт № I

УЛААНБААТАР ХОТОН ШИНЭЭР НЭЭЖ АЖИЛЛУУЛАХ  
ХИМИ ЦЭВЭРЛЭГЭЭ, УГААЛГЫН ХҮЛЭЭН АВАХ,  
ОЛГОХ ЦЭГ

- 1. Октябрийн районы ОСГ-ны 4-р хороо  
Бөөний худалдааны нэгдлийн ажилчдын орон сууцанд
- 2. Найрамдлын районы ОСГ-ны 2-р хорооны нутаг дэвсгэрт
- 3. Найрамдлын районы ОСГ-ны 4-р хороо  
15-р хороололд, орон сууцны байранд
- 4. Сүхбаатарын районы ОСГ-ны 11-р хороо  
6-р хорооллын үйлчилгээний төвд
- 5. Ажилчны районы ОСГ-ны 13-р хороо  
Биокомбинатад орон сууцны барилгад
- 6. Ажилчны районы ОСГ-ны 14-р хороо:  
ХААДС-ийн хичээлийн байранд
- 7. Найрамдлын районы ОСГ-ны 12-р хороо  
Амгалангийн гэр хороололд
- 8. Сүхбаатарын районы ОСГ-ны 16-р хорооны нутаг дэвсгэрт
- 9. Октябрийн районы ОСГ-ны 32-р хороо  
4-р хорооллын үйлчилгээний төвд
- 10. Октябрийн районы ОСГ-ны 16-р хороо  
Телевизийн гэр хороололд
- 11. Октябрийн районы ОСГ-ны 13-р хороо  
Төмөр замын хороололд
- 12. Ажилчны районы ОСГ-ны 5-р хороо "Туул" комбинатын  
дэргэд хими цэвэрлэгээний хүлээн авах олгох болон  
угаалгын хүлээн авах, олгох /2 цэг/

Улаанбаатар хотын АДХ-ын гүй-  
цэтгэх захиргааны 1987 оны  
тоот тогтоолын  
хавсралт № 2

ҮЙЛДВЭР, АЛБАН ГАЗРЫН ДЭРТЭД ШИНЭЭР  
НЭЭЖ АЖИЛЛУУЛАХ ХҮЛЭЭН АВАХ, ОЛГОХ  
ЦЭГ

1. Байшин үйлдвэрлэх комбинат
2. Улсын хэвлэлийн комбинат
3. Дөвшил сангийн аж ахуй
4. ТЭЦ-3
5. Хүүхдийн II
6. Гутлын үйлдвэр
7. Эх нялхсын төв
8. 28 дугаар авто бааз
9. 22 дугаар авто бааз
10. Бөөний худалдааны бараа бааз